



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 51/100

Номгон

Ц.Алтантуяаг ажилд томилох тухай


Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, байгууллагын Дотоод журмын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цэрэндоржийн Алтантуяаг Байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийн шийдвэрээр 2022 оны 11 дүгээр сарын 22-ний өдрөөс эхлэн Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан хоол зүйчийн албан тушаалд томилон ажиллуулсугай.

2.Бодлогын баримт бичгийг бүрэн гүйцэт хяналтандаа авч, түүний хэрэгжилт, холбогдох тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэн, баталгаажуулж, хийгдсэн ажлын үр дүнг тайлагнан, хариуцлагатай ажиллахыг Ц.Алтантуяад үүрэг болгосугай.

3.Ц.Алтантуяагийн үндсэн цалинг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2-дугаар хавсралтад зааснаар ТҮ-6 дугаар зэрэглэл буюу 740.619 (Долоон зуун дөчин мянга зургаан зуун арван ес) төгрөгөөр тооцон бодож олгохыг ахлах нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ

642201420